

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 23 оны .1.1 сарын .06 дөр

№ R-2023-72

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн Дүрмийн 8.6 (ii) дахь заалт болон Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 06-ны өдрийн хооронд зохион байгуулсан цахим санал хураалтын үр дүнг үндэслэн:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банк нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар 61.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 19.1%-д хүргэж ажилласан болохыг;
2. Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах асуудал нь стратегийн асуудал болохыг;
3. Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2023 оны эхний хагас жилийн ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг бэлэн мөнгөөр хуваарилах (“**Хагас жилийн ногдол ашиг**”)-ыг ТУЗ-д санал болгосныг; мөн
4. ТУЗ нь Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу дор дурдсан дүнгээр Хагас жилийн ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, Хагас жилийн ногдол ашигт нийт 15,527,325,000.00 (арван таван тэрбум таван зуун хорин долоон сая гурван зуун хорин таван мянга) төгрөг буюу нэгж хувьцаанд 14.75 (арван дөрвөн төгрөг далан таван мөнгө) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, хагас жилийн ногдол ашиг хуваарилах асуудлыг шийдвэрлэх Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“**ХЭЭБХ**”)-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг түүний зохион байгуулагдах хэлбэрээс үл хамааран, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор ногдол ашгийг бэлэн мөнгөөр төлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь ХасБанкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр

хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ